



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

2021 оны 01 сарын 08 өдөр

Дугаар Е/01

Төрийн ордон, Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА
ГОМБОЖАВЫН ЗАНДАНШАТАР ТАНАА

Улсын Их Хурлын шийдвэрийн
төсөл өргөн мэдүүлэх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ хүрээнд “Коронавируст халдварын цар тахлаас үүдэлтэй амьдралын доройтол, нийгэм, эдийн засгийн бэрхшээлийг даван туулах онцгой арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг санаачлан боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Зохих журмын дагуу хэлэлцүүлж өгнө үү.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

ХАЛТМААГИЙН
БАТТУЛГА



2020000115



📅 2021/01/08 2:49:35

Коронавируст халдварын цар тахлаас үүдэлтэй амьдралын доройтол, нийгэм, эдийн засгийн бэрхшээлийг даван туулах онцгой арга хэмжээний тухай УИХ-ын тогтоолын төсөл

Коронавируст халдварын цар тахал дэлхий нийтэд тархах болсонтой холбогдуулан манай улс 2020 оны 02 дугаар сарын 13-ны өдрөөс өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжиж, иргэн, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг хязгаарлан, хорио цээрийн тусгай дэглэм тогтоосон бол халдвар дотоодод алдагдсан 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрөөс бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжиж нийт 19 хоног, 2020 оны 12 дугаар сарын 23-ны өдрөөс 2021 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийг хүртэл нийт 14 хоногийн хугацаанд тус тус хатуу хөл хорионы дэглэм тогтоож, 2020 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийг хүртэл 5 хоногоор дахин сунгаад байна.

Цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэхтэй холбогдуулан иргэн, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг нийт 11 сарын турш хязгаарлсан, 38 хоног бүрэн зогсоосон зэрэг нь айл өрхүүдийн амьдралд хүндээр тусаж, амьжиргаагаа залгуулдаг орлого нь тасалдах, огт орлогогүй болгох туйлын хүнд нөхцөлд хүргээд байна.

Ард иргэдийн амьдрал доройтох, үндэсний үйлдвэр, аж ахуйн нэгжүүд дампуурах, улс орны эдийн засаг туйлдах бодит аюул тулгарч байгаатай холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгч дэлхий нийтийн жишгээр иргэн, аж ахуйн нэгжээ дэмжих, улсын төсөв, хөрөнгийг бодитойгоор хэмнэж зөвхөн цар тахлын хүндрэлийг даван туулахад онцгой анхаарах санал, санаачилгыг удаа дараа гаргасан.

Дэлхийн улс орнууд цар тахлын аюул гамшгийг даван туулахын тулд тухайн өвчинтэй тэмцэхээс гадна ард иргэддээ мөнгөн тусламж үзүүлэх, худалдан авалтаар нь дамжуулан үйлдвэр, аж ахуйгаа санхүүжүүлэх зэрэг нэн оновчтой, тодорхой арга хэмжээг шуурхай хэрэгжүүлж, улс орныхоо эдийн засагт тулгарсан хямрал, үйлдвэр аж ахуйн доройтол, ард иргэдийнхээ амьдралд учирч буй зовлон, бэрхшээлийг цогцоор шийдвэрлэх, алсын хараатай, үр дүнтэй, дэмжлэгийн бодлогыг тууштай явуулж байна.

Иймд Монгол Улсын Ерөнхийлөгч Үндсэн хуулийн Хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ хүрээнд "Коронавируст халдварын цар тахлаас үүдэлтэй амьдралын доройтол, нийгэм, эдийн засгийн бэрхшээлийг даван туулах онцгой арга хэмжээний тухай" Улсын Их Хурлын тогтоолын төслийг санаачлан боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлээд байна.

Энэхүү тогтоолын төсөл нь цар тахлын хүнд үед "өрх бүрд нэг сая төгрөг"-ийн дэмжлэг үзүүлэх, өрхийн худалдан авалтаар дамжуулан үндэсний үйлдвэр, аж ахуйгаа дэмжих үндсэн зорилгын хүрээнд боловсруулагдсан бөгөөд санхүүжилтыг нь "оффшор бүсээс татагдсан" хөрөнгийн эх үүсвэрээр шийдвэрлэнэ.

Та бүхэн Монголын Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан энэхүү тогтоолын төсөлтэй танилцаж, санал хүсэлтээ илэрхийлнэ үү.

1. Үзэл баримтлал

2. Танилцуулга

3. Тогтоолын төсөл